

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Равжаа	Дугаар	L154
Оршин суугаа аймаг	Баянхонгор	Оршин суугаа сум	Эрдэнэцогт
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дайчин вангийн хүрээ	Сүм хийдийн дугаар	БХЭЦ 084
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 19	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Дайчин вангийн хүрээ

Асуулт:-Та Дайчин вангийн хүрээний 1990 онд сэргэсэн тухай?

Хариулт:-1987 онд Чунагийн Цэрэндорж гэгч Улаанбаатар Гандантэгчилэн хийд, Монгол улсын соёлын яам зэрэг газруудаар энэ хийдийг сэргээн байгуулахаар өргөдөл хүсэлт гаргаж хөөцөлдөж байсан боловч зөвшөөрөл авч байсан боловч энэ ажил хэрэг болоход яриа арай болж өгөхгүй, ахин дахин хөөцөлдүүлж 1990 оныг хүргэж Ардчилал, хүний эрх чөлөө чөлөөтэй болсны дараа Монгол Улсын Соёлын яамнаас манай аймгийн Ламын гэгээний хийдийг сэргээн байгуулах шийдвэр гарч, манай хийдийг сэргээхийг хойшлуулан зөвшөөрөхгүй болсныг үл ойшоон тус сумын дээд доод хоёр хүрээнд шавилан сууж байсан 60-80 насны 34 өвгөчүүл 1990 оны 6 сарын 1 буюу морин жилийн зуны эхэн сарын шинийн 8-нд Цогчэн хурлаа хурж сүсэгтэн олноо баясган, хурал номын газар хуучин уламжилж байсан ёс жаягаараа нээгдэн ажлаа эхэлсэн билээ.

Чунагийн Цэрэндорж гэдэг хүн дэд тэргүүн ламаар нь, Тэргүүний Өлзий гэдэг хүн ловон ламаар, Жийн Дамдин гэдэг хүн **гэсгүй** ламаар, **Бядраны** Батаа гэдэг хүн их үнзад ламаар, Догийн Түмэн гэдэг лам да **үнзад** ламаар,

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Нямын Бэх-Очир гэдэг лам **човомбо** ламаар, Гончигийн Мятав гэдэг хүн дуганч ламаар, Жанчивын Готов гэдэг хүн дуганч ламаар, Долгорын **Цэрмээ** гэдэг хүн зам буюу тогоочоор. Ингээд хурлын ламд Чимидийн Готов, Сэр-Одын Дамдинсүрэн, Гүндийн Рэнцэн, Рэндоогийн Түндэв, Жигжийн Бүгд, Раднаагийн Бат-Очир, Рэндоогийн Цэдэндамбаа, **Дамдингийн** Лувсан, Цогийн Гунгаа, Цэндийн Готов, Цэдэнжавын Доржжанцан, Цэдэнжавын **Цэдэнзамба**, Сэрсэнгийн Нанзад, Пунцагийн Готов, Балжидын Бямба, Балжидын Балжинням, Гомбын Жүгдэр, **Сүрьяагийн** Шагдар, Цэндийн Гомбодорж, Намжилын Ядамсүрэн, Гунгаагийн Гэндэн, Янжингийн Самбуу, Дагвын Сүх, Гэндэнгийн Дамдин эдгээр 34 лам нар хурал номынхоо үйл ажиллагааг даана, бусад гадуур жас болон аж ахуйн ажилд доорх хүмүүсийг авч ажиллуулсан.

Аж ахуйн даргаар Жамцын Болдбаатар, нягтлан бодохоор **Гэрэлийн** Дагва, аж ахуйн даргаар Цэрэндоржийн Чулуунбат, тогоочоор **Нямчимэдийн** Бямбаа, үйлчлэгч цэвэрлэгчээр Агвааны Нарантуяа, жолоочоор Бэх-Очирын Сүхбат, сахиул манаачаар Жанцан, малчнаар Дэмбэрэлийн Очиржанцан нарыг тус ажиллуулан даргад 400, ня-бод 400, жолоочид 400, няравт 300, тогоочид 200, цэвэрлэгчид 180, **манаачид** 200, малчинд 200, зам, дуганч лам нарт 50, бусад лам нарт 30 төгрөгийн цалинтайгаар сард анх ажиллуулсан.

Байгуулагдсанаасаа хойш 1993 онд асартай хаалга бүтээж, энэ байж байгаа энэ гоё сайхан асартай хаалгыг бүтээн байгуулсан, 2003 онд шинэ өвлийн дугантай болох зорилгоор **дуганын** суурийг тавьж 2004 онд шинэ өвлийн дугантай болж 21 сая төгрөгөөр бүтээгдсэн ийм гоё дугантай болсон. Манай үйл ажиллагаанд. Энэ хооронд гэгээд, хутагт, хувилгаад, Бакула **ренбүүчи, Агууру ренбүүчи** олон хол ойрын лам нар олноор заларч, мөн **Ганжуур, Данжуурыг** 108 ботиудыг ёслол төгөлдөртэй залж, олон ард түмэн сүсэгтэн олныг мөргүүлж, бишрэл, өргөл үйлдэж байсан ийм түүхт үйл явдлуудыг хийж байсан. Ингээд 2007 онд ширээнд залагдаж байгаа **Банчин ренбүүчи** бол 12 настай, анх 1990 онд манайд өвөө Дамдингаа дагаж энд шавилан сууж байсан ийм хүүхэд. Ингээд үүнээсээ хойш шашны ном сургуулиар явж, ингээд гэгээнтэн тодорч, энэ жил ширээний ламаар залагдаж ийм баяртай үйл явдал болж байна даа, манай түүхэн үйл явдлаас яривал. Үлдэж байгаа ганц сүмийн тухайд асуудал бол хэлмэгдэлтийн үед анх эхлээд буулгах гэж байхад нь манай эндхийн нутгийн лам байсан залуу чадалтай хүн буулгуулахгүй гэж тэмцэж, тэр хүмүүстэй зодоон цохион ч болдог юмуу, ингэж хорьсны улмаас хэрэг таслагдаж, тэгээд тэр газар ямар ч гэм хийгээгүй, тэр хийдийг буулгасан хүнтэй би ерөөсөө үзнэ гэж **ярьдагаар** 3 жил **гарангийн** ял сонсож, тэгээд тэр хүнийг л аварсан гэж ингэж Хожгорын Чулуунбат гэдэг хүн байсан. Их сайн бөх. Өвөрхангай аймагт очиж барилдаж, даншигт түрүүлж байсан ийм их бяртай, чадалтай, аагтай ийм залуу хүн байсан гэж бөхчүүл ярьдаг юм билээ. Тэр хүний авралаар хоцорсон юм. Тэрнээс анх энийг буулгах гэж хоёр хүн ирж буулгаж байсныг ирээд оройн дээд **сүмээс** нь авч байхад тэр хүн ирж зодоон цохион болсон юм байна лээ. Тэгээд тэрнээс болж үлдээд, тэгээд тэр хүн **яхав** тэр тухайдаа хэрэг таслагдаж, ирэхэд нь буулгаагүй орхисон. Ингээд дараа нь сум, орон нутгийн музей болгож ашиглаж байгаад, артелийн үйлдвэр явуулдаг, гутал улладаг, ажилчид доод талд нь юм оёдог, дээд талд нь үйлдвэрлэлээ явуулдаг ийм газар байлгаж байгаад тэгээд 90 онд сүм хийд болгож манайх хүлээж авсан юм даа.

Асуулт:-Одоо ямархуу байдалтай байна, байшин барилга нь.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.  
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Анх эхлээд байгуулагдахдаа 1903 онд байгуулагдсан гэж тэр Эрдэнэцогтын түүх номон дээр бичигдсэн байдаг юм байна лээ. Одоо **тэрүүгээрээ** болох юм бол 104, 105 настай ийм л эд юм. Одоо бол баруун хойд зүгтээ яльгүй жаахан 10 хэдэн см-ийн суулт **суучихаад** л байгаа юм. Тэрнээс өөр ямар ч гэмтэл байхгүй. Будаг шунхыг нь 1987 онд улсын Соёлын төвийг сэргээх газраас ирж будгийг нь сэлбэсэн. Өөр засвар ороогүй. Өөрөө байгаа хэмжээндээ байж байгаа ийм л сүм дээ.

Одоо тэр суултыг нь **засч** өгөхгүй бол хойш **хойшдоо** улам сууж байгаад ер нь хойшоогоо нурах зам руу орж мэднэ гэсэн ийм аймшиг төрдөг юм. Энэ талаар аймагт танилцуулсан. Улсууд ирж үзсэн, **засч** болно, энийг төсөв төлөвлөгөөнд оруулна. Тэгэхдээ **архитекторын** газар гэсэн байхаа даа үзэж шалгадаг тийм газраар үзүүлж шалгуулна, акт гарга гэсэн ийм л үүрэг даалгавартай байдаг юм. Бид засуулах талаасаа ярьж хөөрдөг л юм. Одоо яахын аргагүй ч биш. **Баганых** нь **углуурганууд** ингээд **ангайчихаад** байгаа юм.

Асуулт:-Одоо хичнээн ламтай үйл ажиллагаа явуулж байгаа билээ?

Хариулт:-90 онд анх нээгдэхэд шавилан сууж байсан манай гэгээнтний **чацуутан** 9 ламтан, тэрнээс хойш үргэлжлэн өөрсдийнхөө сайн дураар шавилан суусан жижиг хүүхдүүд нийлсэн 14 ламтай, аж ахуйн хүмүүс өөрчлөгдсөн хүн байхгүй, аж ахуйн дарга гэж байхгүй болсон. Бусад нь манаач, тогооч хоёр бол хоёр хүн байсан эхний нээгдэхэд. Энэ ганц хүн болсон. Ийм л маягтай ажиллаж байна даа.

Асуулт:-Сүмийн тэргүүн хамба ямар хүн байна?

Хариулт:-Одоогоор манай хийдийн хамбаар Дагвасүрэн гэдэг хүн байна. Лам. Манай гэгээнтэнтэй цуг л шавилж сууж байсан ийм жижиг хүүхэд байгаа. **Гэсгүйгээр** нь Батбаатар гэдэг лам байна, мөн ялгаагүй. Ингэж л шавилж суусан залуу. Их **үнзадаар** нь Очирваань гэдэг хүн байна, энэ мөн ялгаагүй. Бага **үнзадаар** нь Батгэрэл гэдэг ийм лам ажиллаж байна.